



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Алтанширээ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/7/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Сайншанд сум

2020 он

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын захирал
бөгөөд тэргүүлэх аудитор Ч.Ариунаа

Утас: 99092469 Цахим хаяг: ariunaach@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Энхцэцэг

Утас: 90077079 Цахим хаяг: enkhtsetsege@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Уваа уул” аудит ХХК

Утас: 99108763 Цахим хаяг: uwaauul.audit@gmail.com

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	19
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам

1. Аудитын гэрчилгээ



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

ДОРНОГОВЬ АЙМГИЙН
АЛТАНШИРЭЭ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Л.МӨНХ-ЕРТӨНЦ
ТАНАА

2020.02.28 № 1-6/192
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Алтанширээ сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Дорноговь аймгийн Алтанширээ сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Алтанширээ сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал


Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй 18,541.0 мянган төгрөгийн зөрчил нь санхүүгийн тайлангийн хэмжилт, үнэн зөв байдал, иж бүрэн байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Алтанширээ сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Л.Мөнх-Ертөнц танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох, зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Алтанширээ сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Алтанширээ сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-аас 2020 оны 02 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын захиалгаар “Уваа-уул аудит” ХХК –ийн захирал Ч.Мөнхтуяа, чанар хяналтын менежер А.Оюун, аудитор Ц.Мөнхтуяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Дорноговь аймгийн Алтанширээ сумын ерөнхий боловсролын сургууль нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 04 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорноговь аймаг дахь Алтанширээ сумын ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Өөрийгөө илэрхийлэх чадвартай, үндэсний хэл соёл түүхэн уламжлалаа дээдэлсэн байгальд ээлтэй, бүтээлч иргэнийг төлөвшүүлэх”-д оршино.

Дорноговь аймаг дахь Алтанширээ сумын ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

“Төрийн албаны тухай” шинэчилсэн хуулийг дагаж гарсан эрх зүйн актууд 2019 оноос эхлэн үйлчилж байна. Тухайлбал:

- Журам батлах тухай (Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл олгох) Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол
- Журам батлах тухай (Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох) Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоол
- Журам батлах тухай (Нөхөх төлбөр олгох) Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоол
- Журам батлах тухай (Төрийн албан хаагчид шагнал олгох, ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн мөнгөн урамшуулал олгох) Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол
- Журам батлах тухай (төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин урамшуулал олгох) Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоол
- Түрээсийн сурах бичиг ашиглуулах талаарх БСШУСС-ын 2019 оны А/302 дугаар тушаал
- Нийгмийн даатгалын тухай хуульд 2017 онд орсон өөрчлөлтийн дагуу шимтгэлийн хувь хэмжээний өөрчлөлт зэрэг болно.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Дорноговь аймгийн Алтанширээ сумын ерөнхий боловсролын сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорноговь аймгийн Алтанширээ сумын ерөнхий боловсролын сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн “Acolous-3” программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Алтанширээ сумын ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд эрсдэлтэй гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорноговь аймгийн Алтанширээ сумын ерөнхий боловсролын сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 12 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 4 дүгээр улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээс 1.0 хувийг сонгов.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1.0 хувиар тооцсон нь эрсдэлийн түвшин “дунд” гэж үзсэнтэй холбоотой юм.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 4,445.9 мянган төгрөгөөр тооцсон нь төлөвлөлтийн үе шат болон нийт зардлын дүнтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Алтанширээ сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 39,918.5 мянган төгрөгөөр буюу 3.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	1,423.9	1,423.9
Авлага	81.0	688.1	607.1
Урьдчилгаа	0.0		0.0
Бараа материал	76,724.7	84,969.4	8,244.7
Үндсэн хөрөнгө	938,835.8	888,641.6	-50,194.2
Нийт хөрөнгө	1,015,641.4	975,723.0	-39,918.5
Өр төлбөр	1,320.0	214.5	-1,105.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,014,321.5	975,508.5	-38,813.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,015,641.4	975,723.0	-39,918.5

Бараа материал дансны үлдэгдэл өссөн шалтгаан нь тайлант жилийн эцэст багаж, техник хэрэгсэл, тавилгын зардлаас 12,965.4 мянган төгрөгийн хөгжим, техник хэрэгсэл худалдаж авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 50,194.2 мянган төгрөгөөр буурахад тайлант үеийн элэгдлийн зардал голлон нөлөөлсөн байна. Тайлант жилд 9,140.4 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө худалдаж авсан, БСШУСЯ-наас 5,555.5 мянган төгрөгийн ном, сурах бичиг авч орлого болгосон, 2,022.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж, данснаас хассан, 11,120.0 мянган төгрөгийн эд хөрөнгийг хүүхдийн цэцэрлэгт шилжүүлсэн зэрэг хөдөлгөөн гарсан байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөрт зориулан 395,369.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 362,292.0 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 33,077.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Гүйцэтгэлээр нийтдээ 395,346.6 мянган төгрөгийг зарцуулсан нь батлагдсан төсөвтэй харьцуулахад 99.99 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Нэмэлт төсөв: Нэмэлт төсвийн дансаар нийтдээ 3,356.9 мянган төгрөгийн орлого хүлээж авсан байна. Үүнд: түрээсийн номын орлого, заалны түрээсийн орлого зэрэг орлогоос гадна нярвын дутагдуулсан хүнсний материалын 1,746.3 мянган төгрөгийг нэмэлт төсвийн дансанд тушааснаар хүнс худалдаж авсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 12, аудитор илрүүлж хэрэгжүүлсэн 4, нийтдээ 16 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 67,149.5 мянган төгрөгийн 9 алдаа, зөрчил илэрснээс, 41,128.5 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 21,241.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 4,780.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Аудитын явцад дараах 41,128.5 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг залрууллаа.
Үүнд:

1. Дотоод журамд заасны дагуу байгууллагын ажиллагсад тус бүр 1 тн, нийтдээ 27 тн нүүрсийг олгож, 2,700.0 мянган төгрөгийг түлш халаалтын зардалд бичсэн байсныг нэг удаагийн тэтгэмжийн зардалд залруулсан.
2. Ажиллагсад олгосон урьдчилгаанаас 100.0 төгрөгийн урьдчилгааг суутгалгүй цалингийн зардалд бичсэнийг залруулж, авлагаар бүртгүүлэв.
3. БСШУСЯ-аас ирүүлсэн 685.3 мянган төгрөгийн түрээсийн сурах бичгийг орлогод аваагүй орхигдуулсан байсныг орлогод авхуулав.
4. Нярав Болортуяагийн дутагдуулсан 1,746.3 мянган төгрөгийн хүнсний материалыг бүртгэлээс хасахдаа авлага үүсгэлгүйгээр хоолны зардалд бичсэн байсныг залруулж, авлага үүсгүүлэв.
5. Орон нутгийн төсвөөс санхүүжсэн 33,074.6 мянган төгрөгийн санхүүжилтийг буруу дансаар бүртгэсэн байсныг болон жилийн эцэст төвлөрүүлсэн мөнгөн

хөрөнгөөр төсвийн гүйцэтгэлийн тохируулга хийгээгүй, төсвийн гүйцэтгэл зөрүүлсэн байсныг засаж, төрийн сангийн хуулгатай таарууллаа.

Аудитаар дараах 26,021.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 21,241.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлжээ. Үүнд:

1. Тус сургууль нь дотуур байрны хүүхдийн хоолны худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулаагүй байв.
Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар бүлгийн 6.1 “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.” заалт, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4 “хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох;” заалт, Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.” заалт, Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7 дугаар зүйлийн 7.13.1. заалтад заасан “төсвийн тухай хуулийн 24.4, 25.10, 44.3-т заасан;” зарлагын гүйлгээ хийхийг хориглох заалтуудыг тус тус зөрчиж, “эрх ба үүрэг” батламж мэдэгдэлд нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөв.

2. Дотоод журамд заасны дагуу байгууллагын ажиллагсад тус бүр 1 тн, нийтдээ 27 тн нүүрсийг олгож, 2,700.0 мянган төгрөгийг түлш халаалтын зардалд бичсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4.1.10. заалтад заасан “төсвийн зарлага” гэж төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр батлагдсан төсвөөс хуваарилан, зарцуулах хөрөнгийг; гэсэн заалт, Сангийн сайдын 2014 оны 3 дугаар сарын14-ны 55 дугаар тушаалын хавсралтаар баталсан төсвийн зарлагын эдийн засгийн ангилалд “уурын болон дулааны халаалтад холбогдсон байгууллага үйлчлэгч байгууллагатай байгуулсан гэрээний дагуу төлөх дулааны эрчим хүч болон халуун усны төлбөр, мөн түүнчлэн ердийн халаалтын зууханд хэрэглэх аргал, түлээ, нүүрс, мод зэрэг түлшинд гарсан зардлыг харуулна.” гэсэн заалтуудыг тус тус зөрчиж, төсөвт батлагдаагүй зарлагыг гаргаж, “үнэн зөв ба үнэлгээ ” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөв.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Аудитын явцад анхаарал татсан дараах асуудал байна. Үүнд:

1. Өмнөх аудитын зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Алтанширээ сумын ерөнхий боловсролын сургуулийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 139 мэдээллийг хугацаанд нь, 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар худалдан авах ажиллагаатай холбоотой 71,098.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлсэн боловч 2019 онд уг алдааг давтаж гаргасан байх тул зөвлөмжийн биелэлтийг хангаж ажиллаагүй гэж үзэж байна.

Тус сургуулиас аудитын явцад зөвлөмжийн биелэлтийн талаар баримт, материал ирүүлээгүй болно.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Алтанширээ сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 26,021.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тооцсон 4,445.9 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Дорноговь аймгийн Алтанширээ сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал

- 3.1.1 Илрүүлэлт: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар бүлгийг зөрчиж элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 17 нэр төрлийн 11672,3 мянган төгрөгийн анхны өртөгтэй үндсэн хөрөнгө ашиглагдаж байна.
- 3.1.2 Эрсдэл: Санхүүгийн тайланд толилуулсан хөрөнгийн үнэ цэнэ буруу илэрхийлэгдэх, санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд буруу мэдээлэл өгөх үр дагавартай.
- 3.1.3 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах
- 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2 Балансын данстай холбоотой асуудал

- 3.2.1 Илрүүлэлт: Балансын дансанд тусгасан 2303,6 мянган төгрөгийн өр, авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 заалтын “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах,....баталгаажуулах;” гэсэн заалттай нийцэхгүй, “Үнэн зөв байх”, “ Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- 3.2.2 Эрсдэл: Өр, авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүйгээс дараагийн тайлангийн үеүдэд өр, авлагаа хүлээн зөвшөөрөхгүй байх, төлөхгүй байх зэрэг эрсдэлийг үүсгэж болзошгүй.
- 3.2.3 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, өр, авлагыг тухай бүрд нь тооцоо нийлж баталгаажуулах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.3 Зардлын данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт: Дотуур байрны хүүхдийн хоол нормативаас 2476,4 мянган төгрөгөөр хэтэрсэн байна. Энэ нь Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолоор баталсан хоолны зардлын дундаж нормативыг баримтлаагүй, “Үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3.2 Эрсдэл: Нормативыг мөрдөж ажиллахгүйгээс зардал хэтрэх эрсдэлтэй.

3.3.3 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, батлагдсан норм, нормативыг баримталж ажиллах.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолоор баталсан хоолны дундаж норматив нь одоогийн хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлттэй уялдахгүй байгаагаас гадна хүүхдийн хоногийн илчлэг, үндсэн шимт бодисын хэрэгцээг хангаж чадахгүй байна. Мөн Эрүүл мэндийн сайдын 113 дугаар тушаалаар хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ нь тухайн бүтээгдэхүүний цэвэр жин байхыг заасан боловч орон нутагт ясгүй мах нийлүүлэх иргэн, аж ахуйн нэгж байдаггүй.

Дээрх 3 зөвлөмжийн биелэлтийг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	76,805,679.20	87,081,409.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	1,423,930.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	1,423,930.00
3121	Төгрөг	00.00	1,423,930.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	1,423,930.00
33	АВЛАГА	81,000.00	688,106.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	81,000.00	81,000.00
335	Бусад авлага	00.00	607,106.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	607,106.00
35	БАРАА МАТЕРИАЛ	76,724,679.20	84,969,373.00
351	Түүхий эд материал	26,246,332.00	37,791,552.00
35110	Тусгай зориулалттай материал	26,246,332.00	37,791,552.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	4,200.00	804,010.00
354	Хангамжийн материал	50,474,147.20	46,373,811.00
35410	Бичиг хэргийн материал	24,000.00	359,360.00
35420	Аж ахуйн материал	23,801,079.20	19,792,378.00
35440	Түлш, шатах тослох материал	13,969,000.00	14,884,000.00
35460	Хүнсний материал	7,880,770.00	6,753,275.00
35470	Бусад хангамжийн материал	4,799,298.00	4,584,798.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	938,835,753.90	888,641,568.80
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	938,835,753.90	888,641,568.80
392	Биет хөрөнгө	922,385,753.90	872,191,568.80
39201	Барилга, байгууламж, орон сууц	911,847,430.00	911,847,430.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-70,430,483.47	-105,764,997.79
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	97,856,425.11	93,474,788.11
39206	Хуримтлагдсан элэгдэл	-57,774,464.46	-62,897,864.59
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	56,919,648.20	55,666,265.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-36,818,680.18	-39,458,271.33
39214	Бусад үндсэн хөрөнгө	24,726,200.00	24,024,800.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-9,426,806.16	-16,122,375.96
39217	Ном	5,486,484.86	11,421,794.86
393	Биет бус хөрөнгө	16,450,000.00	16,450,000.00
39301	Програм хангамж	110,000.00	110,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-110,000.00	-110,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	16,450,000.00	16,450,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	1,015,641,433.10	975,722,977.80
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,319,980.00	214,525.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,319,980.00	214,525.00
413	Өглөг	1,319,980.00	214,525.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,301,980.00	00.00
4136	Бусад өглөг	18,000.00	214,525.00
41361	Байгууллагад төлөх өглөг	18,000.00	166,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	48,525.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,014,321,453.10	975,508,452.80
51	Засгийн газрын хувь оролцоо	1,014,321,453.10	975,508,452.80
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	753,106,201.20	753,106,201.20
51101	Өмч: - төрийн	753,106,201.20	753,106,201.20
512	Хуримтлагдсан үр дүн	-570,072,304.22	-608,885,304.52
51210	Өмнөх үеийн үр дүн	-570,072,304.22	-570,072,304.22
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-38,813,000.30
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	831,287,556.12	831,287,556.12
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,015,641,433.10	975,722,977.80

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	455,720,239.00	405,774,408.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	57,204,100.00	7,279,430.00
120	Нийтлэг татварын бус орлого	57,204,100.00	7,279,430.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	57,204,100.00	7,279,430.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,723,930.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	57,204,100.00	5,555,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	398,516,139.00	398,494,978.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	398,516,139.00	362,292,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	398,516,139.00	362,292,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	3,125,978.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	3,125,978.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	33,077,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	33,077,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	432,194,833.39	443,205,075.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	432,194,833.39	443,205,075.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	413,162,359.39	432,471,986.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	213,866,140.00	263,660,032.00
210101	Үндсэн цалин	147,419,600.00	192,924,932.00
210102	Нэмэгдэл	44,570,060.00	48,636,900.00
210104	Урамшуулал	21,876,480.00	22,098,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,627,500.00	33,596,882.00
210201	Тэтгэврийн даатгал	18,994,300.00	23,062,780.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,151,700.00	2,657,452.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,733,400.00	2,139,924.00
210204	Ажилгүйдлийн даатгал	431,600.00	521,427.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,316,500.00	5,215,299.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,789,156.00	27,422,230.00
210301	Гэрэл, цахилгаан	2,940,581.00	3,304,530.00
210302	Түлш, халаалт	24,142,500.00	24,049,000.00
210303	Цэвэр, бохир ус	706,075.00	68,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,496,441.00	17,656,812.20
210401	Бичиг хэрэг	2,247,700.00	2,526,130.00
210402	Тээвэр, шатахуун	2,459,800.00	1,362,560.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	555,091.00	523,617.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	370,000.00	1,460,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,863,850.00	3,011,080.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	8,773,425.20
2105	Нормативт зардал	19,849,655.00	22,170,475.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	307,250.00	321,000.00
210502	Хоол, хүнс	19,542,405.00	21,686,975.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	162,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	61,644,107.00	684,864.00
210604	Урсгал засвар	61,644,107.00	684,864.00

2107	Томилолт, зочны зардал	820,000.00	2,248,900.00
210702	Дотоод албан томилолт	820,000.00	2,248,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	586,000.00	719,029.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	586,000.00	719,029.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,483,360.39	64,312,761.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,174,720.00	250,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	173,000.00	555,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	52,135,640.39	63,507,761.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,032,474.00	10,733,089.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,397,600.00	10,710,715.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,481,400.00	7,210,715.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,916,200.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	3,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,634,874.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,634,874.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	2,385.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	2,385.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	19,989.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	19,989.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	23,525,405.61	-37,430,667.19
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	363,096,134.03	1,382,333.11
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	1,382,333.11
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	363,096,134.03	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-363,096,134.03	-1,382,333.11
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-339,570,728.42	-38,813,000.30

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	398,516,139.00	400,218,908.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	1,723,930.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	1,723,930.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	1,723,930.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,723,930.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	398,516,139.00	398,494,978.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	398,516,139.00	362,292,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	398,516,139.00	362,292,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	3,125,978.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	3,125,978.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	33,077,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	33,077,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	390,198,347.00	389,654,568.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	390,198,347.00	389,654,568.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	371,104,353.00	380,870,194.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	213,536,160.00	265,709,000.00
210101	Үндсэн цалин	147,419,600.00	194,973,900.00
210102	Нэмэгдэл	44,570,060.00	48,636,900.00
210104	Урамшуулал	21,546,500.00	22,098,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,627,500.00	33,376,000.00
210201	Тэтгэврийн даатгал	18,994,300.00	23,720,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,151,700.00	1,931,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,733,400.00	2,414,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	431,600.00	482,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,316,500.00	4,827,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,281,156.00	31,074,630.00
210301	Гэрэл, цахилгаан	2,940,581.00	3,495,630.00
210302	Түлш, халаалт	28,634,500.00	27,393,000.00
210303	Цэвэр, бохир ус	706,075.00	186,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,707,141.00	5,492,667.00
210401	Бичиг хэрэг	436,500.00	357,640.00
210402	Тээвэр, шатахуун	1,698,950.00	1,633,560.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	707,791.00	623,617.00
210404	Ном, хэвлэл	134,200.00	118,550.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	370,000.00	1,460,000.00
210406	Бага үнэгэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	359,700.00	1,299,300.00
2105	Нормативт зардал	19,481,350.00	21,396,355.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	359,250.00	360,000.00
210502	Хоол, хүнс	18,372,300.00	20,286,355.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	749,800.00	750,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	68,472,226.00	16,345,113.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,180,619.00	2,965,400.00
210602	Тавилга	00.00	10,000,000.00
210604	Урсгал засвар	61,291,607.00	3,379,713.00
2107	Томилолт, зочны зардал	820,000.00	2,248,900.00

210702	Дотоод албан томилолт	820,000.00	2,248,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	644,000.00	719,029.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	644,000.00	719,029.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,534,820.00	4,508,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,174,720.00	450,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,360,100.00	4,058,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,093,994.00	8,784,374.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,459,120.00	8,762,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,542,920.00	7,962,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,916,200.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	800,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,634,874.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,634,874.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	2,385.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	2,385.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	19,989.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	19,989.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	8,317,792.00	10,564,340.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	8,317,760.00	9,140,410.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,317,760.00	9,140,410.00
2200	Дотоод эх үүсвэрээр	8,317,760.00	9,140,410.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,317,760.00	9,140,410.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-8,317,760.00	-9,140,410.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	32.00	1,423,930.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	32.00	1,423,930.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	736,656,201.20	788,669,291.40	-527,471,220.15	997,854,272.45
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	736,656,201.20	788,669,291.40	-527,471,220.15	997,854,272.45
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	60,076,739.60	60,076,739.60
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	753,106,201.20	831,287,556.12	-570,072,304.22	1,014,321,453.10
2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	753,106,201.20	831,287,556.12	-570,072,304.22	1,014,321,453.10
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	753,106,201.20	831,287,556.12	-570,072,304.22	1,014,321,453.10
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-38,813,000.30	-38,813,000.30
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	753,106,201.20	831,287,556.12	-608,885,304.52	975,508,452.80

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	395,369,000.00	395,346,626.00	22,374.00	99.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	395,369,000.00	395,346,626.00	22,374.00	99.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	386,607,000.00	386,584,626.00	22,374.00	99.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	265,709,000.00	265,709,000.00	00.00	100.00
210101	Үндсэн цалин	194,973,900.00	194,973,900.00	00.00	100.00
210102	Нэмэгдэл	48,636,900.00	48,636,900.00	00.00	100.00
210104	Урамшуулал	22,098,200.00	22,098,200.00	00.00	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,376,000.00	33,376,000.00	00.00	100.00
210201	Тэтгэврийн даатгал	23,720,000.00	23,720,000.00	00.00	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,931,200.00	1,931,200.00	00.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,414,100.00	2,414,100.00	00.00	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	482,800.00	482,800.00	00.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,827,900.00	4,827,900.00	00.00	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,077,000.00	31,074,630.00	2,370.00	99.99
210301	Гэрэл, цахилгаан	3,497,500.00	3,495,630.00	1,870.00	99.95
210302	Түлш, халаалт	26,799,500.00	27,393,000.00	593,500.00	102.21
210303	Цэвэр, бохир ус	780,000.00	186,000.00	594,000.00	23.85
2104	Хангамж, бараа материалын зардал	5,874,000.00	5,872,477.00	1,523.00	99.97
210401	Бичиг хэрэг	200,000.00	357,640.00	157,640.00	178.82
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	1,633,560.00	133,560.00	108.90
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	686,000.00	623,617.00	62,383.00	90.91
210404	Ном, хэвлэл	656,000.00	498,360.00	157,640.00	75.97
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,532,000.00	1,460,000.00	72,000.00	95.30
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,300,000.00	1,299,300.00	700.00	99.95
2105	Нормативт зардал	19,651,000.00	19,650,105.00	895.00	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	360,000.00	360,000.00	00.00	100.00
210502	Хоол, хүнс	18,541,000.00	18,540,105.00	895.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	750,000.00	750,000.00	00.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,000,000.00	22,999,985.00	15.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,000,000.00	11,000,000.00	00.00	100.00
210602	Тавилга	10,000,000.00	10,000,000.00	00.00	100.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	1,999,985.00	15.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	2,250,000.00	2,248,900.00	1,100.00	99.95
210702	Дотоод албан томилолт	2,250,000.00	2,248,900.00	1,100.00	99.95
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	720,000.00	719,029.00	971.00	99.87
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	720,000.00	719,029.00	971.00	99.87

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4950000.00	4934500.00	15,500.00	99.69
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	150,000.00	150,000.00	00.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,800,000.00	4,784,500.00	15,500.00	99.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8762000.00	8762000.00	00.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,762,000.00	8,762,000.00	00.00	100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,962,000.00	7,962,000.00	00.00	100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	00.00	00.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	800,000.00	00.00	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	395,369,000.00	395,346,626.00	22,374.00	99.99
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	362,292,000.00	362,272,011.00	19,989.00	99.99
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	362,292,000.00	362,272,011.00	19,989.00	99.99
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	33,077,000.00	33,074,615.00	2,385.00	99.99
132001	Орон нутгийн төсвөөс	33,077,000.00	33,074,615.00	2,385.00	99.99
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	00.00	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	27.00	27.00	00.00	100.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00	00.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00	00.00	100.00

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,125,978.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,125,978.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,125,978.00
2105	Нормативт зардал	1,746,250.00
210502	Хоол, хүнс	1,746,250.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,379,728.00
210604	Урсгал засвар	1,379,728.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,125,978.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,125,978.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,125,978.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020-02-25			ДГА-2020/7/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Дорноговь аймгийн Алтанширээ сумын ерөнхий боловсролын сургууль		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Худалдан авах ажиллагаа хууль журмын дагуу зохион байгуулаагүй	18541,0	Албан шаардлага өгөх	Захирал Нягтлан бодогч	Л.Мөнх-Ертөнц Ч.Бямбасүрэн
2	Ажиллагсад түлээ нүүрс олгохдоо түлш, халаалтын зардлаар тайлагнасан	2700,0	Албан шаардлага өгөх	Захирал Нягтлан бодогч	Л.Мөнх-Ертөнц Ч.Бямбасүрэн
3	Элэгдлээрээ анхны ертгөө нөхсөн "0" үлдэгдэлтэй үндсэн хөрөнгүүд ашиглагдаж байна.	0	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Л.Мөнх-Ертөнц Ч.Бямбасүрэн
4	Балансын дансанд тусгасан өр, авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	2303,6	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Л.Мөнх-Ертөнц Ч.Бямбасүрэн
5	Дотуур байрны хүүхдийн хоол нормативаас хэтэрсэн байна.	2476,4	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Л.Мөнх-Ертөнц Ч.Бямбасүрэн